

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

**БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ХЭЛТСИЙН ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН ДЭЛГЭРСАЙХАНЫ САЙХАНЧИМЭГ
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. “Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтын хүрээнд”							
Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр.							
Стратеги төлөвлөгөөний зорилго 1: 3.4 заалт. Улаанбаатарын онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх, жуулчдын ая тухтай аялах, зорчих нөхцөлийг бүрдүүлнэ.							
3.4.5. Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах чиглэлээр гадаад хамтын ажиллагааг эрчимжүүлнэ.							
1.	Арга хэмжээ-1: Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг олон улсад сурталчлах	Оролцсон, зохион байгуулсан олон улсын үзэсгэлэнгийг, арга хэмжээ, хурал, уулзалтын тоо	3	2	2025 оны эхний хагас жилийн байдлаар гадаад харилцааны чиглэлээр нийт 8-н арга хэмжээг зохион байгуулж зорилт тавьсан тоо хэмжээг давуулан биелүүллээ. - “Ай Ти Би Берлин-2025” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн - Дэлхийн аялал жуулчлалын хотуудын холбооны ээлжит чуулга уулзалт - “КОТТМ 2025” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн - “Улаанбаатар хотын соёлын өдрүүд” - “Франц хотхон” соёл, аялал жуулчлалын арга хэмжээ - “СИТФ 2025” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн	2025.01.01 2025.06.05	100%

					- Дэлхийн хотуудын Аялал жуулчлалыг дэмжих хотуудын холбоонд элсэх - БНХАУ-ын аялал жуулчлалын байгууллагын 100-н төлөөллийг Улаанбаатар хоттой танилцуулах арга хэмжээнүүдийг зохион байгуулахад шаардагдах төсвийг гаргаж захирамжийн төсвийг боловсруулан Нийслэлийн удирдлагуудаас санал авч батлуулах, газрын даргын тушаалын төслийг бэлтгэн санал авах, батлуулах, арга хэмжээг зохион байгуулахтай холбогдолтой гэрээг байгуулах, арга хэмжээнд оролцох төлөөлөгчдийн тийз захиалах, байгууллагын оролцоог хангах, тайлан, илтгэх хуудсыг батлуулан хүргүүлэх ажлыг тус тус гүйцэтгэн ажиллав.		
2.	Арга хэмжээ-1.1: ХБНГУ-ын Берлин хотод зохион байгуулагдах "Ай Ти Би"-Берлин олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцох	Хэрэгжилтийн хувь	/-	/-/+	Захирамжийн дугаар: Нийслэлийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/123 Хугацаа: 2025 оны 03 дугаар сарын 03-07 Оролцоо, хийгдсэн ажлууд: ITB Berlin 2025 олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд АЖМХ-ны Европын зах зээлийн салбар холбооны 13 тур операторын төлөөлөл 100м2 талбайд үйл ажиллагаагаа танилцуулан оролцлоо. Энэхүү оролцооны хүрээнд Монгол Улс руу чиглэсэн жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх, түнш байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, Европын зах зээлд үйл ажиллагаагаа тэлэх зорилгоор нийт 250 гаруй бизнес уулзалт амжилттай зохион байгуулсан болно. Үзэсгэлэнд оролцох зардлыг дэмжих хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын зүгээс 47,580,000 /дечин долоон сая таван зуун наян мянга/, 1050 /нэг мянга тавь/ ам. долларын санхүүгийн дэмжлэг үзүүлж, үзэсгэлэнгийн үеэр Улаанбаатар хотыг сурталчлах Герман хэл дээрх 500 ширхэг танилцуулга сэтгүүл тараан сурталчилгаа хийв. Мөн үзэсгэлэнгийн гурван өдрийн турш нийт 24 удаагийн	2025.01.01 2025.06.05	100%

				уулзалт хийсэн бөгөөд уулзалтын үр дүнг нэгтгэсэн Илтгэх хуудсыг үзэсгэлэнгээс хойш долоо хоногийн дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон холбогдох газрын дарга, хэлтсийн дарга нарт албан ёсоор хүргүүлсэн болно. Үр дүн: TPO (Tourism Promotion Organization for Global Cities) байгууллагатай уулзалт хийсэн. Энэхүү уулзалтын үр дүнд Улаанбаатар хот 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр тус байгууллагад гишүүнээр элсэх хүсэлтээ албан ёсоор хүргүүлсэн. Уг хүсэлтийг TPO-ийн холбогдох хурлаар хэлэлцэн, 2025 оны 5 дугаар сарын 14-ний өдөр БНХАУ-ын Гуанжоу хотод зохион байгуулагдсан Ерөнхий Ассамблейн хурлаар Улаанбаатар хотыг албан ёсоор гишүүнээр элсүүлэх шийдвэрийг баталгаажуулсан. Энэ нь Улаанбаатар хотын олон улсын харилцааг өргөжүүлэх, аялал жуулчлалын чиглэлээр гадаад хамтын ажиллагааг бэхжүүлэх чухал алхам боллоо. БНХАУ-ын Хайнань мужийн Саньяа хотын Аялал жуулчлалын газартай уулзалт хийсэн. Уулзалтаар хоёр хотын аялал жуулчлалын хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар санал солилцсон бөгөөд бидний урилгаар Саньяа хотын төлөөлөгчид 2025 оны 5 дугаар сарын 16-18-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Улаанбаатар Травел Экспо” арга хэмжээнд оролцохоор хүрэлцэн ирсэн нь үр дүнтэй хамтын ажиллагааны эхлэл болсон. Монгол Улсаас ХБНГУ-д суугаа Элчин сайдтай уулзсан. Монгол Улсаас Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Б.Мандахбилэгтэй уулзаж, Улаанбаатар хотын аялал жуулчлалын салбарыг олон улсын түвшинд сурталчлах, Германы холбогдох байгууллагуудтай хамтын ажиллагаа хөгжүүлэх чиглэлээр санал солилцсон. Энэхүү уулзалт нь Монгол Улсын аялал жуулчлалын сонирхлыг Герман зэрэг Европын зах зээлд таниулахад чиглэсэн цаашдын хамтын	
--	--	--	--	--	--

					ажиллагааны суурийг тавьсан. 2025 оны 3 дугаар сарын 3-7-ны өдрүүдэд Герман улсын Берлин хотод зохион байгуулагдсан ITB Berlin олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцох томилолт нь Улаанбаатар хотын аялал жуулчлалын салбарыг олон улсын зах зээлд сурталчлах, гадаадын түнш байгууллагуудтай хамтын ажиллагааны шинэ боломжуудыг эрэлхийлэх, дэлхийн аялал жуулчлалын чиг хандлагын талаар шинэ мэдлэг, мэдээлэл авах чухал алхам болсон.		
3.	Арга хэмжээ-1.2: БНХАУ-ын Бээжин хотод зохион байгуулагдах КОТТМ олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцох	Хэрэгжилтийн хувь	/-/	/-/	Захирамжийн дугаар: Нийслэлийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А/415 Хугацаа: 2025 оны 04 дүгээр сарын 24-26 Оролцоо, хийгдсэн ажлууд: Арга хэмжээнд Соёл, Спорт, Аялал Жуулчлал, Залуучуудын Яам, Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны Хятад зах зээлийн салбар холбооны төлөөллүүд, Улаанбаатар театрын 5 уран бүтээлчид оролцсон. Үзэсгэлэнд 5,000 гаруй Хятадын аялал жуулчлалын оператор компани оролцсон бөгөөд 40 гаруй удаагийн Бизнес уулзалтууд зохион байгуулагдаж, хамтын ажиллагааны санамж бичиг байгуулах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн нийлүүлэх зэрэг арга хэмжээнүүд зохион байгуулагдав. Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас тухайн үзэсгэлэнгийн 60м2 талбайн түрээсийн зардалд 46,500,000 /дөчин зургаан сая таван зуун мянга/, 1280 /нэг мянга хоёр зуун наян ам.долларын санхүүгийн дэмжлэг үзүүлж Хятад хэл дээр хэвлэгдэн гарсан Улаанбаатар сэтгүүл 800 ширхэг, газрын зургийн танилцуулга 800 ширхэг сурталчилгааны материалуудыг тараасан. Үр дүн: Хятадын болон олон улсын аутбаунд компаниудтай В2В уулзалт зохион байгуулсан нь Монгол Хятад хоёр орны аялал жуулчлалын хамтын ажиллагааг өргөжүүлэх, Монгол улсыг Хятадад сурталчлан таниулах таатай нөхцөлийг бий болгож, Хятадын аялал жуулчлалын компаниудад өөрсдийн үйл ажиллагаа таниулах болон аяллын	2025.01.01 2025.06.05	100%

					бүтээгдэхүүнийг шууд борлуулах бололцоотой болсон. Үзэсгэлэнгийн үеэр Хятадын болон олон улсын аутбаунд компаниудтай B2B уулзалтыг зохион байгуулж МУ-ын аялал жуулчлалын нөхцөл байдал сурталчлан таниулж, өөрийн компанийн аяллын бүтээгдэхүүн үйлчилгээг шууд борлуулах боломжоор хангагдсан.		
4.	Арга хэмжээ-1.3: БНСУ-ын СИТФ олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцох	Хэрэгжилтийн хувь	/-/	/-/	Захирамжийн дугаар: Нийслэлийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А/415 Хугацаа: 2025 оны 06 дугаар сарын 05-08 Оролцоо, хийгдсэн ажлууд: Арга хэмжээнд Соёл, Спорт, Аялал жуулчлал, Залуучуудын яам, Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны удирдах зөвлөл болон тус холбооны Солонгос зах зээлийн салбарын есөн аялал жуулчлалын компанийн төлөөлөл, Улаанбаатар театрын таван уран бүтээлч оролцлоо. Үзэсгэлэнгийн үеэр Солонгос хэл дээр хэвлэгдсэн “Улаанбаатар” сэтгүүлийн 500 ширхэгийг тараахаар төлөвлөсөн бөгөөд Улаанбаатар театрын уран бүтээлчид үзэсгэлэнгийн төв тайзан дээр өдөрт хоёр удаа тоглох цагийг баталгаажуулсан. Үзэсгэлэнгийн бэлтгэл ажлын хүрээнд уран бүтээлчдийн виз мэдүүлэх, нислэгийн тийз захиалах, зочид буудал болон унааны зохицуулалтыг бүрэн гүйцэтгэж, зохион байгуулалтын бүх шатны ажлыг амжилттай хийж гүйцэтгэлээ. Түүнчлэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 44,235,000 /дөчин дөрвөн сая хоёр зуун гучин таван мянга/ төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж, уг санхүүжилттэй холбоотой захирамж, тушаал, холбогдох баримт бичгүүдийг бүрдүүлэн гаргасан болно.	2025.01.01 2025.06.05	100%
5.	Арга хэмжээ-1.4: АНУ-ын Чикаго хотноо зохион байгуулагдах “IPW” олон улсын аялал	Хэрэгжилтийн хувь	/-/	/-/	2025 оны төсөвт суугдаагүй тул үнэлгээнээс хасаж өгнө үү.	2025.01.01 2025.06.05	-

	жуулчлалын үзэсгэлэнд оролцох						
6.	Арга хэмжээ-1.5: Япон улсын Токио хотод зохион байгуулагдах "JATA" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцох	Хэрэгжилтийн хувь	/-/	/-/	Тухайн үзэсгэлэн нь 2025 оны 9 дүгээр сарын 25–28-ны өдрүүдэд зохион байгуулагдах бөгөөд уг арга хэмжээний талаарх мэдээ, мэдээллийг нэгтгэн боловсруулж, бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	2025.06.01 2025.12.01	-
7.	Арга хэмжээ-1.6: Олон улсын аялал жуулчлалын болон гадаад улсын мэргэжлийн холбоодтой хамтын ажиллагаа өргөжүүлэх	Хамтран ажилласан олон улсын байгууллага, холбоодын тоо	1	1	Арга хэмжээ 1. Захирамжийн дугаар: Нийслэлийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/347 Хугацаа: 2025 оны 04 дүгээр сарын 15-16 Оролцоо, хийгдсэн ажлууд: Бүгд Найрамдах Хятадын Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Хонгконг хотноо "Хотын брэнд бүтээлтээр аялал жуулчлалын чанарыг дээшлүүлэх нь" сэдвийн хүрээнд Дэлхийн аялал жуулчлалын хотуудын холбооны (WTCF) ээлжит чуулга уулзалт амжилттай зохион байгуулагдлаа. Тус арга хэмжээнд гадаад, дотоодын 43 орны 60 гаруй хотын төлөөлөгчид, аялал жуулчлалын байгууллагууд, судлаачид оролцож, салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх, туршлага солилцох, шинэ хандлага, шийдлүүдийг танилцуулах чухал платформ боллоо. Чуулганы үеэр 570 гаруй хоёр талт уулзалт зохион байгуулагдаж, 100 гаруй аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгч болон худалдан авагч оролцсон юм. Мөн тус холбооны зүгээс жил бүрийн чуулганд гишүүн хотуудаас хоёр төлөөлөгчийг зардлын бүрэн санхүүжилттэйгээр оролцуулах боломжийг олгодог нь онцлог юм. Үр дүн: Улаанбаатар хот тус чуулга уулзалтад амжилттай оролцож, аялал жуулчлалын салбар дахь олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, бодлого боловсруулагчид болон мэргэжлийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, цаашлаад шинэ санаа, чиг хандлагыг нутагшуулах	2025.01.01 2025.12.01	100%

				чухал алхам боллоо. Мөн Улаанбаатар хотыг олон улсад аялал жуулчлалын шинэ чиглэл болгон сурталчлах, соёл, түүх, байгаль, орон нутгийн онцлогт суурилсан аялал жуулчлалыг хөгжүүлэх шинэ боломжуудыг бий болгож чадлаа. Чуулганы үеэр Улаанбаатар хотоос “Гадаад жуулчдыг хотын брэнд бодлогоор татах нь” сэдвийн хүрээнд 5 минутын танилцуулгыг амжилттай хүргэж, хотынхоо нэрийг олон улсын тавцанд таниулах чухал боломжийг бүрдүүлсэн. Түүнчлэн, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот 2027 онд тус холбооны дээд хэмжээний уулзалтыг өөрийн нутаг дэвсгэрт зохион байгуулах санал, санаачилгыг албан ёсоор дэвшүүлж, анхны хэлэлцээг эхлүүлсэн нь энэхүү оролцооны нэг чухал үр дүн боллоо. Мөн тус холбооны албан ёсны цахим хуудсанд манай байгууллагаас зохион байгуулсан арга хэмжээний талаарх мэдээллийг 2025 оны эхэнд байршуулсан нь олон улсын хүрээнд бидний үйл ажиллагааг таниулах, олон нийтэд хүргэхэд чухал нөлөө үзүүлэхэд хувь нэмэрээ оруулж байна. Арга хэмжээ 2. Захирамжийн дугаар: Нийслэлийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А/415 Хугацаа: 2025 оны 05 дугаар сарын 14 Хийгдсэн ажлууд: ТРО (Tourism Promotion Organization for Global Cities) буюу Дэлхийн хотуудын аялал жуулчлалыг дэмжих байгууллагад элсэх хүсэлтийг хүргүүлж, Улаанбаатар хотын тухай танилцуулга материал, мэдээлэл болон нийслэлийн талаарх эссэг боловсруулан илгээсэн. Уг хүсэлтийг БНХАУ-ын Гуанжоу хотноо зохион байгуулагдсан ТРО-гийн Ерөнхий Ассамблейн хурлаар хэлэлцэн, Улаанбаатар хотыг гишүүнээр элсүүлэх шийдвэрийг албан ёсоор баталгаажуулсан. Энэ шийдвэрийн дагуу хоёр жил тутамд зохион байгуулагддаг Ерөнхий Ассамблейн ээлжит хурал 2025 оны 9 дүгээр сарын 3–6-ны өдрүүдэд Вьетнам улсын Хо Ши Минь хотод болох	
--	--	--	--	--	--

				бөгөөд тус хуралдаанаар Улаанбаатар хотын гишүүнчлэлийн батламжийг гардуулах урилгыг бидэнд ирүүлсэн. Мөн БНСУ-ын Пусан хотноо болох “Дэлхийн хотуудын аялал жуулчлалын дээд хэмжээний уулзалт”-д Улаанбаатар хотыг албан ёсоор урьсан бөгөөд уг арга хэмжээнд гишүүн хотуудын хотын дарга нарын түвшний уулзалт зохион байгуулагддаг онцлогтой. Энэхүү дээд хэмжээний уулзалтад оролцогчдын бүх зардлыг зохион байгуулагч байгууллагаас бүрэн хариуцахаар болсон нь манай хотын хувьд олон улсын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх чухал ололт амжилт болж байна. Арга хэмжээ 3. Монгол Улсын аялал жуулчлалын салбарын хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор Бүгд Найрамдах Солонгос Улсын Сэжон Их Сургуулийн дэргэдэх аялал жуулчлалын салбарын дата шинжилгээний лаборатори болох TIDAL төвтэй хамтран ажиллах талаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Хамтын ажиллагааны хүрээнд аялал жуулчлалын салбар дахь инноваци ба дижитал шилжилт, бүс нутгийн маркетинг, хоолны урлаг ба нийтийн хоолны үйлчилгээний шинэ техникүүд, тогтвортой аялал жуулчлалын менежмент, зочид буудлын борлуулалтын менежмент, хүнсний аюулгүй байдал ба НАССР тогтолцоо, орлогын менежмент, стратегийн харилцаа холбоо, хиймэл оюун ухааныг зочлох үйлчилгээ ба аялал жуулчлалд ашиглах зэрэг сэдвийн хүрээнд сургалт, судалгаа, туршлага солилцох олон талт үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа ба үүний үндсэн дээр хамтын ажиллагааны санамж бичиг байгуулахаар ажиллаж байна. Арга хэмжээ 4. Бүгд Найрамдах Солонгос Улсын Бусан хотын Гимхэ дээд сургуулийн Ерөнхий захиралтай албан ёсны уулзалт хийж, хоёр талын хамтын	
--	--	--	--	--	--

					ажиллагааны эхлэлийг амжилттай тавьсан. Уг уулзалтын хүрээнд аялал жуулчлалын салбарын хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх, ялангуяа Монгол Улсын аялал жуулчлалын салбарын ажилтнуудын солонгос хэлний мэдлэг, харилцааны ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр хамтран ажиллах талаар харилцан санал солилцож, хамтын ажиллагааны хүрээг тодорхойлох эхний алхмуудыг хийсэн болно. Цаашид аялал жуулчлалын салбарт ажиллах хүчнийг зориулсан солонгос хэлний мэргэжлийн сургалт, соёлын солилцоо, богино хугацааны чадавхжуулах хөтөлбөр, солонгост сургалт, дадлага хийх боломж зэргийг хамарсан цогц хамтын ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэхээр зорьж байна.		
8.	Дэлхийн явган алхалтын холбоонд элсэх	Хэрэгжилтийн хувь	/-/	/-/	Арга хэмжээ 1. Монголын явган алхалтын холбоотой хамтран Дэлхийн явган алхалтын холбоо болох IML Walking Association-д Монгол Улсын гишүүнээр элсэх хүсэлтийг албан ёсоор хүргүүлээд байна. Үүний хүрээнд 2025 оны 11 дүгээр сарын 15–16-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Индонез Улсад зохион байгуулагдах олон улсын явган алхалтын арга хэмжээнд Монгол Улс, тэр дундаа Улаанбаатар хот нь Нийслэлээс санаачлан хэрэгжүүлж буй “Улаанбаатар олон улсын явган алхалтын фестиваль”-ийн тухай албан ёсны танилцуулга хийх эрхийг авсан нь маш том амжилт болж байна. Энэхүү оролцоо нь 2026 оноос эхлэн “Улаанбаатар олон улсын явган алхалтын фестиваль”-ийг дэлхийн олон улсын явган алхалтын албан ёсны хуанлид бүртгэгдэн орох боломжийг нээж, дэлхийн мянга мянган алхагчдад Монгол Улсыг сурталчлах, Улаанбаатарыг аялал жуулчлалын шинэ чиг хандлагын нэг болгон таниулах чухал алхам болох юм. IML холбоонд элсэхийн тулд хэд хэдэн тодорхой шалгуурыг хангах шаардлагатай байдаг. Улаанбаатар хот эдгээр бүх шалгуурыг бүрэн хангасан бөгөөд хамгийн чухал шалгуурын нэг	2025.06.01 2025.12.01	100%

					болох стандартын шаардлага хангасан явган алхалтын замтай байх гэсэн шаардлагыг биелүүлэхийн тулд тодорхой арга хэмжээ авч ажилласан. Тухайлбал, 2025 оны 06 дугаар сарын 13–15-ны өдрүүдэд зохион байгуулагдах Азийн явган алхалтын фестиваль-д Богд хан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны албан хаагчдыг оролцуулах боломжоор хангаж, олон улсын стандартад нийцсэн замнал, хамгаалалт, орчны зохион байгуулалтын чиглэлээр туршлага хуримтлуулах боломжийг бүрдүүлээд байна.		
9.	Найрамдалт харилцаат, ах, дүү хотуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх	Найрамдалт харилцаат хотуудад зохион байгуулсан арга хэмжээний тоо	/-/	/-/	Захирамжийн дугаар: Нийслэлийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/470 Хугацаа: 2025 оны 05 дугаар сарын 05-14 Оролцоо, хийгдсэн ажлууд: Монгол Улс, Унгар Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 75 жилийн ойн хүрээнд хоёр орны найрсаг харилцааг бэхжүүлэх, үндэсний соёл, уламжлалыг сурталчлах, жуулчдыг татах зорилгоор Аялал жуулчлалын салбарын төлөөллүүд Улаанбаатар хотыг сурталчлах цогц арга хэмжээг Унгарт амжилттай зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээнд Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны Европ зах зээлийн салбар холбооны гишүүн 8 байгууллага, Монголын Гастрономийн Холбоо, Морьт Харвааны Холбоо зэрэг салбарын төлөөллүүд оролцсон юм. Хөтөлбөрийн хүрээнд Монголын Гастрономийн Холбоо үндэсний таван тансаг идээний амталгаат үзэсгэлэнг зохион байгуулж, 500 гаруй хүнд уламжлалт хоол хүнсний өв соёлыг танилцуулсан. Үзэсгэлэнд цайны ёслол, уламжлалт тариа, махан болон сүүн бүтээгдэхүүн, баярын зоогийн 20 нэр төрлийн бүтээгдэхүүн багтсан нь жуулчдын анхаарлыг ихээхэн татав. Мөн Морьт Харвааны Холбооноос газрын харвааг циркийн үзүүлбэртэй хослуулан сонирхолтой арга хэмжээ зохион байгуулсан нь Монголын нүүдлийн соёлыг таниулах чухал үйл ажиллагаа боллоо. Түүнчлэн "Монголын	2025.01.01 2025.06.01	100%

					талаар хэн сайн мэдэх вэ?" сэдэвт танин мэдэхүйн асуулт, хариултын уралдаан зохион байгуулж, ялагчийг Монгол Улсад аялах эрхийн бичгээр шагнасан нь олон нийтийн сонирхлыг татсан, аялал жуулчлалыг урамшуулах онцлох үйл явдал байлаа. Эдгээр арга хэмжээ нь Улаанбаатар хотыг олон улсын тавцанд сурталчлах, Монголын соёл, уламжлалыг таниулах, цаашдын аялал жуулчлалын хамтын ажиллагааг өргөжүүлэх чухал алхам боллоо. Үр дүн: Будапешт хотын Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын газрын удирдлага болон дипломат харилцаа хариуцсан албаны төлөөллүүдтэй уулзалт хийв. Уулзалтын хүрээнд Будапешт хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээний талаар мэдээлэл солилцсон бөгөөд цаашид хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, мөн Унгар улсын аялал жуулчлалын бодлого үйл ажиллагааг хариуцсан мэргэжлийн холбоотой холбоо тогтоон хамтран ажиллахаар болсон. Мөн энэхүү арга хэмжээ нь Монголын аялал жуулчлалын соёл, өв уламжлалыг олон улсад сурталчлах, Улаанбаатар хотыг шинэ аялал жуулчлалын чиглэл болгон таниулах чухал боломж боллоо. Жуулчдын сонирхол нэмэгдэж, гадаадын хамтын ажиллагааг өргөжүүлэх, аялал жуулчлалын байгууллагуудын гадаад зах зээлд ажиллах чадавх сайжрах суурь тавигдлаа.		
10	Улаанбаатар хотод Найрамдалт харилцаат хотуудын арга хэмжээг зохион байгуулах	Улаанбаатар хотод зохион байгуулсан Найрамдалт харилцаат хотуудын арга хэмжээний тоо	1	1	Арга хэмжээ 1. Захирамжийн дугаар: Нийслэлийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/395 Хугацаа: 2025 оны 04 дүгээр сарын 26,27 Оролцоо, хийгдсэн ажлууд: “Франц хотхон” соёл, аялал жуулчлалын арга хэмжээг Франц улсаас Монгол улсад суугаа элчин сайдын яам, Франц - Монголын аж үйлдвэрийн танхим болон Аллианс Франсез төвтэй хамтран Франц хэл дээр үйл ажиллагаа явуулдаг дипломат, боловсрол соёлын байгууллагууд бизнес худалдаа, франц	2025.06.01 2025.12.01	100%

					бүтээгдэхүүн импортлогч байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаагаа танилцуулж, франц хүнсний бүтээгдэхүүн амталгаа, урлаг соёлын арга хэмжээг зохион байгуулав. Арга хэмжээний бэлтгэл ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас уг арга хэмжээнд нийт 66,540,000 /жаран зургаан сая таван зуун дөчин мянга/ төгрөгийг төсөвлөж тус арга хэмжээний техникийн хэрэгсэл, үйлчилгээ, түрээс болон сурталчилгаатай холбоотой зардалд зарцуулсан. Үр дүн: "Франц хотхон" соёл, аялал жуулчлалын арга хэмжээ нь Улаанбаатар хотын иргэд болон жуулчдад Франц улсын соёл, аялал жуулчлалын онцлог, боломжуудыг танилцуулж, сурталчлахын зэрэгцээ Монгол, Франц хоёр улсын найрсаг харилцааг бататгах, бизнесийн хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан онцгой үйл явдал боллоо. Тус арга хэмжээнд 30 гаруй байгууллага идэвхтэй оролцож, нийт 10,000 гаруй зочид, иргэд хүрэлцэн ирсэн нь олон нийтийн сонирхол, оролцоог илтгэв. Мөн арга хэмжээний шторк видео нийт 30,574 хүнд хүрсэн нь цахим орчин дахь хүрээлэл, анхаарлыг тодорхой хэмжээгээр харуулж байна.		
11	"Японы соёл, аялал жуулчлалын өдрүүд" арга хэмжээг Улаанбаатар хотод зохион байгуулах	Улаанбаатар хотод зохион байгуулсан Найрамдалт харилцаат хотуудын арга хэмжээний тоо	1	1	Арга хэмжээ 2. Япон улсаас Монгол улсад суугаа элчин сайдын яам, Монгол улсаас Япон улсад суугаа элчин сайдын яам болон "Летс травел" ХХК-тай хамтран Япон улсын соёл, аялал жуулчлалын өдрүүд арга хэмжээг 2025 оны 07 дугаар сарын 26,27-ны өдрүүдэд зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	2025.07	-

12	"Солонгосын соёл, аялал жуулчлалын өдрүүд" арга хэмжээг Улаанбаатар хотод зохион байгуулах	Улаанбаатар хотод зохион байгуулсан Найрамдалт харилцаат хотуудын арга хэмжээний тоо	1	1	Арга хэмжээ 3. Бүгд Найрамдах Солонгос улсаас Монгол улсад суугаа элчин сайдын яамтай хамтран Солонгос улсын соёл, аялал жуулчлалын өдрүүд арга хэмжээг 2025 оны 09 дүгээр сарын 06,07-ны өдрүүдэд зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	2025.09	-
13	Олон улсын залуучуудын Аспак чуулга уулзалтын бэлтгэл ажилд орж ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилт	/-/	/-/	JCI байгууллагын 2025 оны Ази, Номхон далайн бүсийн чуулганы уулзалтыг 2025 оны 06 дугаар сарын 12-15-ны өдрүүдэд зохион байгуулж тус чуулганд нийт 3000 гаруй төлөөлөгчид оролцохоор төлөвлөгдөж байгаа ба Нийслэлийн зүгээс зохион байгуулалт болон үйл ажиллагаанд хамтран оролцохоор санал солилцож төлөвлөлт хийн ажиллаж байна. Арга хэмжээний хугацаа болоогүй.	2025.07	100%

Зорилт 2. "Хуулиар олгосон чиг үүргийн хүрээнд"

Газрын дүрмийн 4.1.5. Нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр гадаад, дотоодын байгууллагуудтай хамтарч ажиллах;

14	Арга хэмжээ-2.1: Шууд нислэгтэй болон найрамдалт харилцаат, ах эгч дүүс хотуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100%	100%	2025 оны эхний хагас жилийн байдлаар Улаанбаатар хотын гадаад харилцааг бэхжүүлэх, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд шууд нислэгтэй болон найрамдалт харилцаат хотуудтай идэвхтэй хамтран ажилласан болно. Тухайлбал, БНСУ-ын Сөүл, БНХАУ-ын Бээжин, Тяньжин, Шенжэн, Саньяа, Хонг Конг, Япон Улсын Токио, Унгар Улсын Будапешт, Узбекистаны Ташкент зэрэг хотуудтай харилцаа тогтоож, харилцан албан айлчлалуудыг зохион байгуулж, хамтран ажиллах саналуудаа хүргүүлэн, тухайн хотуудын хөгжлийн чиг хандлага, аялал жуулчлалын бодлогын талаар судалгаа хийж, томилолтын үр дүнгийн тайланг боловсруулан ажилласан. Мөн гадаад харилцааг улам өргөжүүлэх зорилгоор Монгол Улсад суугаа бүх Дипломат төлөөлөгчийн газруудад Улаанбаатар хотын зүгээс	2025.01.01 2025.06.05	100%
----	---	---------------------------------	------	------	--	--------------------------	------

					зохион байгуулсан арга хэмжээнүүдийн урилгыг хүргүүлж, тэдэнтэй хамтын ажиллагааг эрчимжүүлэн ажиллалаа. Түүнчлэн, БНХАУ-аас 100 гаруй тур оператор компанийн төлөөллийг хүлээн авч, хамтын ажиллагааг эхлүүлсэн бөгөөд 2025 оны 6 дугаар сарын 7-8-нд болох "Талын салхи" олон улсын спорт, аялал жуулчлалын наадамд БНХАУ-ын 150 гаруй тамирчдыг урин оролцуулахаар зохион байгуулалтын ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Мөн 2025 оны 3 дугаар сарын 8, 9-ний өдрүүдэд амжилттай зохион байгуулагдсан "Бүргэдийн баяр" арга хэмжээнд Бүгд Найрамдах Киргиз Улсаас бүргэдчдийн төлөөллийг урин оролцуулж, хоёр орны уламжлалт соёл, нүүдэлчин ахуйг сурталчлах, аялал жуулчлалын харилцааг бэхжүүлэх чухал алхам боллоо.		
15	Арга хэмжээ-2.2: Олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх	Хамтран ажилласан байгууллагын тоо	100%	100%	2025 оны эхний хагас жилд Улаанбаатар хотын аялал жуулчлалын олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр үр дүнтэй ажлуудыг зохион байгууллаа. Тухайлбал, гишүүнчлэлийн эрхтэй олон улсын аялал жуулчлалын тэргүүлэгч байгууллагуудын нэг болох Дэлхийн Аялал жуулчлалын хотуудын холбоо (WTCF)-ны зохион байгуулсан Хотын дарга нарын дээд хэмжээний уулзалтад амжилттай оролцож, тус холбооны гишүүн хотуудтай хамтын ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэн, туршлага солилцох, цаашдын хамтын төсөл хэрэгжүүлэх боломжуудыг нээж ажиллалаа. Түүнчлэн Улаанбаатар хот нь аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хоёр олон улсын байгууллагад нэгдэн, гишүүнээр элсэх саналаа албан ёсоор хүргүүлээд байна. Үүнд: Дэлхийн Хотуудын Аялал Жуулчлалыг Дэмжих Байгууллага (Tourism Promotion Organization for global cities), Дэлхийн Явран Алхалтын Холбоо (IML walking association). Эдгээр байгууллагад нэгдсэнээр Улаанбаатар хот нь олон улсын түвшинд аялал жуулчлалын салбарын бодлого боловсруулах, мэдээлэл солилцох, хамтарсан арга хэмжээ, төсөл	2025.01.01 2025.06.05	100%

					хөтөлбөрт оролцох өргөн боломжуудыг бүрдүүлэх бөгөөд гишүүнчлэлийн бэлтгэл ажлуудыг амжилттай хийж гүйцэтгэсэн болно.		
4.1.12. Газрын дүрмийн Нийслэлийн хэмжээнд аялал жуулчлалын салбарын мэдээллийн санг хөтлөх;							
16	Арга хэмжээ-3.1: Хариуцсан ажлын хүрээнд холбогдох бүх төрлийн судалгааг гаргаж, мэдээллийн сан үүсгэх	Үйл ажиллагаа хэрэгжилт, хувь	100%	50%	2025 оны эхний хагас жилийн байдлаар Улаанбаатар хотын аялал жуулчлалыг олон улсын түвшинд сурталчлах, гадаад жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилтын хүрээнд тухайн жилд оролцохоор төлөвлөсөн олон улсын үзэсгэлэн, арга хэмжээнүүдийн судалгааг боловсруулан гаргасан. Энэхүү судалгаанд тухайн үзэсгэлэнг зохион байгуулж буй бүс нутгаас өмнөх жилүүдэд Улаанбаатар хотыг зорин ирсэн жуулчдын тоо, сонирхол, хандлагын мэдээлэл зэргийг багтааж, бүсчлэлээр нь ангилан дүн шинжилгээ хийсэн болно. Дээрх судалгааг ашиглан үзэсгэлэн, арга хэмжээний сонголтыг оновчтой болгохын зэрэгцээ Улаанбаатар хотыг илүү үр дүнтэй сурталчлах маркетингийн стратегийг боловсруулахад чиглүүлж, холбогдох хэлтэс болон газрын дарга нарт хүргүүлэн, бодлого боловсруулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажилласан. Мөн хариуцсан ажлын хүрээнд ах, эгч дүүс хотуудын судалгааг мэдээллийн санд нэмэн аялал жуулчлалын бодлого, үйл ажиллагааны чиглэл, хамтын ажиллагааны боломжуудын талаарх судалгааг боловсруулж, гадаад харилцааны хамрах хүрээг өргөтгөхөөр ажиллаж байна. Үзэсгэлэн арга хэмжээнд оролцох явцдаа олон улсын албан байгууллагуудтай холбоо тогтоож, тэдгээр байгууллагын төлөөлөлтэй харилцах зорилгоор албан ёсны цахим шуудангийн мэдээллийг нэгтгэн, хамтын ажиллагааны мэдээлэл хүргэх масс мэйл системийг байгуулж, харилцааны суурийг тавьсан нь цаашдын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чухал алхам болсон болно.	2025.01.01 2024.06.05	100%
Зорилт:3. “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах” зорилтын хүрээнд							

15.	Арга хэмжээ-4.1: Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэх, Төрийн албаны хууль болон төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдөн ажиллах хэрэгжүүлж	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100%	50%	Ажил мэргэжилтэй холбоотой хууль, тогтоол, захирамж, журам болон байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, дотоод ажил үүргийн хуваарийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж, Албан хэрэг хөтлөлтийн журам, Архивын тухай хууль, холбогдох дүрэм, журмыг төрийн албаны стандартыг хэрэгжүүлэн анхаарч ажиллаж байна. Өөрийн ажил үүрэгтэй холбоотой өгсөн үүрэг даалгавар, шинэ мэдээ мэдээллийг удирдлагуудад танилцуулан, тухай бүр үнэн зөв мэдээллээр ханган биелэлтийг гарган ажиллаж байна.	2025.01.01 2025.06.01	100%
16.	Арга хэмжээ-4.2: Албан хэрэг хөтлөлтийн журам, архивын тухай хууль, холбогдох дүрэм журмыг баримтлан ажиллаж, архивын бүрдүүлэлтийг хийх	Хүлээлгэн өгсөн тоо	3	6	Албан хэрэг хөтлөлтийн журам, Архивын тухай хууль, холбогдох дүрэм журмыг баримтлан, хариуцсан ажлын чиглэлээр хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг гарган, бичиг баримтыг стандартын дагуу архивлаж ажиллаж байна.	2025.01.01 2025.06.05	100%

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Үүрэг даалгавар 1. Улаанбаатар явган алхалтын фестивальд гадаад тамирчдыг хариуцан ажилласан	Үйл ажиллагаа хэрэгжилтийн хувь	-	100%	Захирамжийн дугаар: Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/135 Хугацаа: 2025 оны 02 дугаар сарын 15,16 Улаанбаатар явган алхалтын арга хэмжээний хүрээнд Бүгд Найрамдах Солонгос Улсын Явган алхалтын холбооны ерөнхийлөгч, Жэжү Олле явган алхалтын нийгэмлэгийн дэд захирал, Япон Улсын Миаги Олле явган алхалтын нийгэмлэгийн ахлах мэргэжилтэн, Бүгд Найрамдах Хятад	2025.02	100%

					Ард Улсын ӨМӨЗО-ны Явган алхалтын холбооны дэд тэргүүн зэрэг нэр бүхий төлөөлөгчид Улаанбаатар хотноо хүрэлцэн ирсэн. Эдгээр зочдын хүлээн авалттай холбоотойгоор нисэх онгоцны буудлаас угтах, үдэх, зочид буудал болон хоолны захиалга хийх, хотод байх хугацаанд тэднийг хариуцан зохион байгуулах зэрэг бэлтгэл, зохион байгуулалтын ажлыг төлөвлөгөөний дагуу бүрэн гүйцэтгэлээ.		
2.	Үүрэг даалгавар 2. Улаанбаатар өвлийн наадам арга хэмжээнд урилга хүргүүлэн ажилласан	Үйл ажиллагаа хэрэгжилтийн хувь	-	100%	Захирамжийн дугаар: Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/135 Хугацаа: 2025 оны 02 дугаар сарын 15,16 Арга хэмжээний хүрээнд Гадаад улсаас Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газруудад урилга хүргүүлж, хүрэлцэн ирсэн Элчин сайд болон албан ёсны төлөөллүүдийг угтан авах, арга хэмжээний үеэр хүндэт зочдын зохион байгуулалтад анхаарч ажиллав. Мөн арга хэмжээг дэмжин оролцсон ивээн тэтгэгч байгууллагуудаас ирүүлсэн гарын бэлгийг зочдод хуваарилан тараах ажлыг хариуцан, төлөвлөгөөний дагуу зохион байгууллаа.	2025.02	100%
3.	Үүрэг даалгавар 3. “Наурызын баяр- Нарны баяр” арга хэмжээнд Гадаад улсаас Монгол улсад суугаа дипломат төлөөлөгчийн газруудад урилга хүргүүлэх	Үйл ажиллагаа хэрэгжилтийн хувь	-	100%	Захирамжийн дугаар: Нийслэлийн Засаг даргын А/332 Хугацаа: 2025 оны 3-р сарын 20 Арга хэмжээнд Гадаад улсаас Монгол улсад суугаа нийт 25-н Дипломат төлөөлөгчийн газруудад мэдээлэл болгон урилга хүргүүлэн ажилласан. Мөн арга хэмжээний хөтөлбөр, танилцуулгыг англи хэлнээ орчуулж, олон улсын зочид болон гадаад байгууллагуудад ойлгомжтой,	2025.03	100%

					хүртээмжтэй байдлаар танилцуулах нөхцөлийг бүрдүүлэн ажиллав.		
4.	Үүрэг даалгавар 4. Узбек хоолны өдөрлөг арга хэмжээнд урилга хүргүүлэн, холбогдох мэдээллүүдийг орчуулах	Үйл ажиллагаа хэрэгжилтийн хувь	-	100%	Захирамжийн дугаар: Нийслэлийн засаг даргын 2025 оны А/176 Хугацаа: 2025 оны 04 дүгээр сарын 08-13 Арга хэмжээнд Гадаад улсаас Монгол улсад суугаа нийт 25-н Дипломат төлөөлөгчийн газруудад урилга хүргүүлж, хөтөлбөр танилцуулга зэргийг англи хэл дээр орчуулж ажилласан.	2025.04	100%
5.	Үүрэг даалгавар 5. Азийн явган алхалтын арга хэмжээнд оролцох бэлтгэл ажил	Үйл ажиллагаа хэрэгжилтийн хувь	-	100%	Бүгд Найрамдах Солонгос Улсын Гангнеунг хотноо 2025 оны 6 дугаар сарын 13-15-ны өдрүүдэд зохион байгуулагдах Азийн явган алхалтын арга хэмжээд байгууллагын 8 албан хаагчийг оролцуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллалаа. Энэ хүрээнд оролцогч албан хаагчдын виз мэдүүлгийн тов, шаардлагатай бичиг баримтын жагсаалтыг Солонгосын талаас авч, БНСУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яаманд бичиг төлөвлөн хүргүүлж, холбогдох албан бичиг болон баримт материалыг бүрдүүлэн боловсруулсан. Үр дүнд нь бүх оролцогчийн виз амжилттай гарсан бөгөөд тус арга хэмжээнд оролцох бэлтгэл ажлыг цаашид шат дараатайгаар ханган ажиллаж байна.	2025.06	100%
6.	Үүрэг даалгавар 6. “Улаанбаатар” сурталчилгааны сэтгүүлийн орчуулга хийх, Улаанбаатар хотын аялал жуулчлалын гарын авлага хэвлэмэл материалд хяналт тавин ажиллах	Үйл ажиллагаа хэрэгжилтийн хувь	-	100%	Тус газраас эрхлэн гаргадаг “Улаанбаатар” сэтгүүлийн шинэчилсэн мэдээллүүдийг англи хэлнээ орчуулан, гадаад уншигчдад зориулан боловсруулж хүргэв. Мөн “Эко Улаанбаатар 360 хөтөч” сэтгүүлийн контентыг англи хэлнээ хөрвүүлэн орчуулж, олон улсын зочдод зориулсан мэдээллийн хүртээмжийг сайжруулан	2025.06	100%

					ажиллав. Түүнчлэн 2025 оны "Улаанбаатар хотын аялал жуулчлалын гарын авлага" (Guidebook) болох 110 хуудас бүхий материалыг хянан нягталж, үг үсгийн болон найруулгын алдааг засварлан, хэвлэлд шилжүүлэхэд бэлтгэж хүргүүлсэн.		
--	--	--	--	--	--	--	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
"ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1.	Төрийн албаны тухай хууль, түүнийг дагалдан гаргасан хууль тогтоомжид тусгагдсан төрийн албан тушаалд тавигдах шаардлагуудыг ханган ажиллах хариуцсан чиглэлийн дагуу мэргэжлийн боловсролыг дээшлүүлэх сургалт, уулзалт семинарт хамрагдах, ном товхимол бусад хууль тогтоомж, дүрэм, журмыг уншиж судлах	Сургалтуудад хамрагдах, гадаад хэлний түвшинг дээшлүүлэх	-	-	2025 оны эхний хагас жилийн байдлаар Төрийн албаны тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, дүрэм журмуудад заасны дагуу хариуцсан чиг үүргийн хүрээнд мэргэжлийн ур чадвар, мэдлэг боловсролыг тасралтгүй дээшлүүлэн ажиллаж байна. Энэ хүрээнд дараах сургалт, уулзалт, семинарт хамрагдаж, төрийн албан тушаалд тавигдах шаардлагыг ханган ажиллаж байна. Үүнд: 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр Гадаад харилцааны яамнаас нутгийн захиргааны байгууллагын удирдлага, албан хаагчдад зориулан зохион байгуулсан сургалтад хамрагдсан. Энэхүү сургалтаар төрийн байгууллагуудын гадаад харилцааны чиг үүргийн хэрэгжилт, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд баримтлах зарчим, харилцан уялдаатай хамтран	2025.01 2025.06	100%

					ажиллах арга зүй зэрэг чухал мэдлэг мэдээлэл олж авсан. Байгууллагын ёс зүйн зөвлөлөөс зохион байгуулсан сургалт Албан хаагчдын харилцаа, хандлагыг сайжруулах, стрессгүй, зэрэг уур амьсгал бүхий ажлын орчин бүрдүүлэх зорилгоор сэтгэлзүйч Р.Бадамцэцэгийг урьж, “Хувь хүний сэтгэлзүйн онцлог, өөрийгөө танин мэдэхүй”, “Хосын харилцаа”, “Хүүхдийн хүмүүжил” зэрэг сэдвийн хүрээнд цогц сургалт зохион байгуулсан. Уг сургалт нь хувь хүний сэтгэлзүйн хөгжлийг дэмжих, ажлын болон хувийн амьдралын тэнцвэрийг хадгалахад чухал хувь нэмэр болсон. 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдөр “Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлагын сургалт”-д хамрагдсан. Энэхүү сургалтаар төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, албан үүрэг гүйцэтгэхэд баримтлах зарчим, иргэдтэй харилцах харилцааны соёл, байгууллагын дотоод харилцааг сайжруулах арга барил зэрэг чухал мэдлэгүүдийг олж авсан. Мөн төрийн албаны тухай хууль болон түүнтэй холбоотой бусад хууль, дүрэм, журмуудыг тогтмол уншиж судлан, ажил үүргээ хуульд нийцүүлэн, хариуцлагатай, мэргэжлийн түвшинд гүйцэтгэхийг зорин ажиллаж байна.		
2.	Монгол хэл бичгийн тооны чадвараа дээшлүүлж, Солонгос хэлний танхимын сургалтад хамрагдаж ярианы хэл сурсан байна.	Сургалтад хамрагдаж, шалгалт өгөх	100%	50%	2025 оны 1 дүгээр сараас эхлэн төрийн албан хэрэг хөтлөлтийг кирилл бичгийн хамт Монгол бичгээр давхар эрхлэх болсонтой холбогдуулан монгол бичгийн мэдлэг, хэрэглээний чадвараа дээшлүүлэхэд анхаарч, бие даан суралцаж, бичгийн хэрэглээг дадал	2025.01 2025.06	100%

					болгон хэвшүүлэх чиглэлээр тогтмол ажиллаж байна. Мөн гадаад хэлний мэдлэг, чадвараа нэмэгдүүлэх хүрээнд Солонгос хэлний мэдлэгээ ахиулах зорилгоор БНСУ-ын Конкүк их сургуулийн оюутантай хамтран яриа, сонсголд суурилсан сургалтад хамрагдаж байна. Цаашид 2025 оны эцэс гэхэд Солонгос хэлний түвшин тогтоох TOPIK шалгалтад хамрагдахаар зорьж, өдөр бүр хичээллэн бэлтгэж байна.		
3.	Англи хэлний сургалтад хамрагдах	Сургалтад хамрагдаж, шалгалт өгөх	17 түвшин	19 түвшин	Wall street English 32 оронд 450 салбартай үйл ажиллагаагаа явуулдаг олон улсын англи хэлний сургалтын газарт хамрагдсан ба нийт 20-н түвшинтэй сургалтад шалгалт өгөхөд 17-р түвшин байсан. Иймд уг сургалтад явж 20-р түвшинд хүрснээр багшлах эрх мөн нээгдэнэ. Сургалтад хамрагдан 19-р түвшинд хүрсэн. Ажлын ачаалал сургалтын төвийн зай холдсонтой холбогдуулан түр хугацаанд завсарласан байгаа ба 2025 оны 08 дугаар сараас ахин хамрагдаж эхлэхээр төлөвлөж байна.	2025.01 2025.06	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
(Албан тушаал)

Д.САЙХАНЧИМЭГ 
(Нэр, гарын үсэг)

2025.06.05
(Огноо)

НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)-ЫН ХУУДАС

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)

Д/д	Үүрэг даалгавар	Үүрэг даалгавар өгсөн удирдах албан тушаалтан	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
1.	Үүрэг даалгавар 1. Улаанбаатар явган алхалтын фестивальд гадаад тамирчдыг хариуцан ажилласан	Хэлтсийн дарга	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	-	2025.01	2025.02
2.	Үүрэг даалгавар 2. Улаанбаатар өвлийн наадам арга хэмжээнд урилга хүргүүлэн ажилласан	Хэлтсийн дарга	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	-	2025.01	2025.02
3	Үүрэг даалгавар 3. “Наурызын баяр- Нарны баяр” арга хэмжээнд Гадаад улсаас Монгол улсад суугаа дипломат төлөөлөгчийн газруудад урилга хүргүүлэх	Хэлтсийн дарга	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	-	2025.02	2025.03
4	Үүрэг даалгавар 4. Узбек хоолны өдөрлөг арга хэмжээнд урилга хүргүүлэн, холбогдох мэдээллүүдийг орчуулах	Хэлтсийн дарга	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	-	2025.03	2025.04
5	Үүрэг даалгавар 5. Азийн явган алхалтын арга хэмжээнд оролцох бэлтгэл ажил	Газрын дарга	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	-	2025.05	2025.06
6	Үүрэг даалгавар 6. “Улаанбаатар” сурталчилгааны сэтгүүлийн орчуулга хийх, Улаанбаатар хотын аялал	Хэвлэл мэдээлэл, олон нийтийн харилцаа хариуцсан ахлах мэргэжилтэн	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	-	2025.01	2025.06

жуулчлалын гарын авлага хэвлэмэл материалд хяналт тавин ажиллах						
--	--	--	--	--	--	--

НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР АВСАН:

ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
(Албан тушаал)

Д.САЙХАНЧИМЭГ / *Д.Сайханчимэг* /
(Нэр, гарын үсэг)

2025.06.05
(Огноо)

ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:

Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн
дарга
(Албан тушаал)

С.ТУУЛ / *С.Туул* /
(Нэр, гарын үсэг)

.....
(Огноо)